



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/91

Өвт

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн хяналтын үзлэг явуулах, албан татвар, орон нутгийн замын санг бүрдүүлэх, жолоочийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)
Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад)
Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)
Д. Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
Л.Балжинням (5 дугаар багийн Засаг дарга)
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)
С.Ганхүлэг (Засаг даргын Тамгын газрын нярав)
Ж.Батмөнх (Байгаль хамгаалагч)

2. Сумын ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д ДААЛГАХ нь.

а. Сумын хэмжээнд Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах замын санг бүрдүүлэх, даатгалд хамруулах, техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах.

б. Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах.

622201181

в. Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөр аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт шилжүүлж, татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

г. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй, замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

д. Сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харьяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх ажлыг зохион байгуулах.


г. Батлагдсан хуваарь графикийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 27-оос 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулах.

3. Техникийн үзлэгийн өдрүүдэд нийгмийн хэв журмыг сахиулах, Автотээврийн хэрэгслийн хяналтын үзлэг оношлогоонд бүрэн хамруулах ажлыг ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулахыг Цагдаагийн тасгийн дарга (Д.Энх-Амгалан цагдаагийн ахмад), комиссын дарга (Н.Орхонтуул) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН



622201181

My Doc A-4 zahiramj /Zasag darga/